

Фулбрайтын Оюутны хөтөлбөр

Хөтөлбөрийн товч танилцуулга

Фулбрайтын Оюутны хөтөлбөр нь магистрын зэрэг олгох бүрэн тэтгэлэгт хөтөлбөр. АНУ болон бусад орны ард түмэн хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилготой. Тус хөтөлбөр нь АНУ-ын Төрийн департаментын боловсролын солилцооны хөтөлбөрүүдийн хамгийн том хөтөлбөр нь бөгөөд одоогоор дэлхийн 160 гаруй оронд хэрэгжиж байна.

Фулбрайтын хөтөлбөр нь нийгмийн ухаан, хүмүүнлэг, инженер, эдийн засаг, бизнесийн судалгаа, төрийн болон төрийн албаны судалгаа зэрэг бүх чиглэлээр зарлагддаг ч эрүүл мэндийн салбарт зөвхөн нийгмийн эрүүл мэндийн судалгааны чиглэлээр АНУ-д суралцах боломжтой.

Уг хөтөлбөр манай улсад 1994 оноос хойш хэрэгжиж эхэлсэн. Жилд 13-15 оюутанг хамруулж, магистрын зэргийн бүрэн тэтгэлэг олгодог байна. Оюутны амьдрах байр, хоол хүнс болон бусад холбогдох зардал, сургалтын төлбөр гээд бүх зардлыг даадаг. Мөн хөтөлбөрийн хугацаанд эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалаар бүрэн хангаж, визний төлбөрөөс бүрэн чөлөөлөх нь ээ. Та сурах бичиг, лаптоп зэрэгт ч санаа зовох шаардлагагүй.

Шалгуур үзүүлэлт

- **Ахисан түвшний хөтөлбөр(Хугацаа: 1-8 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Магистрын зэрэг	1-2 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой; <ol style="list-style-type: none">1. Монгол улсын иргэн бөгөөд Монгол улсад оршин суудаг байх.2. Хамгийн багадаа 1.5 жилийн ажлын туршлагатай, бакалаврын зэрэгтэй.3. Англи хэлний TOEFL болон IELTS-ийн хүчин төгөлдөр оноотой байх шаардлагатай.4. Суралцах чиглэлээсээ хамааран IBT 80, PBT/IPT 550, IELTS 6.5 эсвэл IBT 90, PBT/IPT 575, IELTS 7 гэсэн оноотой байх ёстой.5. АНУ-д өмнө нь зорчиж байгаагүй буюу цөөн тоогоор зорчсон бол давуу тал болно. Харин АНУ-ын ногоон карттай бол уг хөтөлбөрт өргөдөл гаргах эрхгүй.	

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



1-3 сар:
Хөтөлбөрийг зарлаж, өргөдөл хүлээ авна; Фулбрайтын өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөх хэрэгтэй. Маягтыг та ЭСЯ-ны вэб сайт дээрээс татаж авах боломжтой. Өргөдлийг ЭСЯ-д зарласан хугацааны дотор биеэр эсвэл шуудангаар илгээнэ.

2



Тавдугаар сард Фулбрайтын анхан шатны шалгаруулалт буюу ярилцлага хийдэг. 7-10 дугаар сарын хооронд шалгарсан оролцогчид АНУ-ын их дээд сургуулиудад элсэлтийн өргөдлөө илгээх бэлтгэл хийж, IBT, GRE/GMAT зэрэг шалгалт өгдөг.

3



10-12 сард АНУ-ын элсэлтийн өргөдлийг илгээнэ. 5-6 сард хариуг зарлаж, 6-р сард Элчин сайдын яамнаас хөтөлбөрийн өмнөх уулзалт зохион байгуулна.



7-8 дугаар сард хөтөлбөр эхэлж, тэнцсэн оролцогчид АНУ-д суралцах болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол

- <https://mn.usembassy.gov/mn/education-culture-mn/scholarships-mn/fulbright-mn/>